

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”
ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 03 дүгээр сарын 16-ны өдрийн
26/16 тоот тогтоолын Хавсралт 1



SOLOMON INVESTMENTS

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Баримт бичгийн төрөл/ Type:

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл
ажиллагааг үнэлэх журам

Хамрах хүрээ/ Area:

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ”
ХХК-ийн ажилтнуудад

Нууцын зэрэглэл/ Confidentiality:

Дотоодод нээлттэй

Баримт бичгийн дугаар/Number:

...нс./26/30...

Боловсруулсан/ Prepared by:

Хуулийн баг

Баталсан/ Approved by:

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ” ХХК-
ийн Төлөөлөн удирдах зөвлөл

Хуудасны тоо/ Page number:

1 хуудас

Хянан нийцүүлэх давтамж:

Жилд 1 удаа

Батлагдсан огноо/ Effective date:

2026 оны 03 дүгээр сарын 16

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ
3. ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ДҮГНЭЛТ
4. ЭРХ, ҮҮРЭГ
5. ХАРИУЦЛАГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь "СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн үйл ажиллагаа болон гишүүдийн ажлын үнэлгээ хийх, түүнийг дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТУЗ-ийн гишүүдийн эрх тэгш, ил тод байдал, зохистой засаглалыг хэрэгжүүлэх, шударга ёсыг хангах, хараат бус байх, нууцыг чандлан хадгалах зарчмыг баримтална.
- 1.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээний шалгуур нь ТУЗ-ийн бүрэлдэхүүний мэргэшлийн болон хувийн зан чанар, тэдний бие даасан хараат бус байдал, багийн хамтын ажиллагаа, төвөгтэй асуудлыг шийдвэрлэх, өөрчлөлтөд дасан зохицох, шинэчлэлд нээлттэй байх чадвар болон хувь хүний идэвх оролцооны түвшин зэрэг ТУЗ-ийн ажлын гүйцэтгэлийн үр дүнд нөлөөлөх чадварт анхаарна.
- 1.4. ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд ТУЗ, түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар санал гаргах, ТУЗ-ийн дарга, гишүүн тус бүрийн үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай гэж үзвэл тэдгээрийн мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж гаргах ба холбогдох сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.
- 1.5. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын дагуу боловсруулагдсан болно.

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

- 2.1. ТУЗ-ийн үйл ажиллагаа болон гишүүдийн ажлын үнэлгээг нийт гишүүдийн дунд үнэлгээний хуудас ашиглан асуулгын аргаар явуулна.
 - 2.1.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх хүснэгт – Хавсралт №1
 - 2.1.2. ТУЗ-ийн гишүүд болон нарийн бичгийн даргыг үнэлэх хүснэгт – Хавсралт №2
- 2.2. Үнэлгээ:
 - 2.2.1 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээг энэхүү үнэлгээний аргачлалын маягтын зохион байгуулж, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо судалгааны үр дүнг боловсруулсны дараа дүн шинжилгээ хийж, дараах зүйлийг тодорхойлон үнэлгээний тайланд тусгана. Үүнд:
 - ТУЗ-ийн ажлын давуу талууд;
 - ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлын давуу талууд;
 - ТУЗ болон хороодын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд;
 - ТУЗ-ийн үнэлгээний үр дүн;
 - ТУЗ-ийн бүрэлдэхүүний үнэлгээний үр дүн;
 - ТУЗ болон хороодын үйл ажиллагааны дотоод баримт бичиг, гүйцэтгэсэн ажлын бусад
 - баримт бичигт хийсэн дүн шинжилгээний үр дүн;
 - сайжруулах зорилгоор цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлын чиглэл, саналууд.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ДҮГНЭЛТ

- 3.1 Үнэлгээг жилд нэг удаа хийнэ.
- 3.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь үнэлгээний хуудсыг бэлтгэж, гишүүдээс үнэлгээ авах талаар мэдээлэл хүргүүлэн, гишүүн тус бүрээр үнэлгээний хуудсыг бөглүүлэн авна.
- 3.3 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь гишүүдийн үнэлгээг нэгтгэн ТУЗ-ийн даргад танилцуулна.
- 3.4 ТУЗ-ийн дарга нь гишүүдийн өгсөн үнэлгээнд дүн шинжилгээ хийж ТУЗ-ийн гишүүд болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 3.5 Үнэлгээний дүн нь Компанийн нууцад хамаарна.

ДӨРӨВ. ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 ТУЗ-ийн гишүүд нь үнэлгээний асуулгын нэг бүрчлэн анхааралтай, сайтар нягталж, үнэн зөвөөр бөглөх үүрэгтэй.
- 4.2 ТУЗ-ийн гишүүд нь ажлын үнэлгээний хуудсыг заавал бөглөж үнэлгээ өгөх үүрэгтэй.
- 4.3 Үнэлгээнд оролцох боломжгүй болсон тохиолдолд тухайн шалтгаанаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэж, ажлын үнэлгээний хуудсыг урьдчилан авч бөглөнө.
- 4.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гишүүн бүрээс үнэлгээний хуудсыг бөглүүлэн авч, үнэлгээг нэгтгэн ТУЗ-ийн даргад танилцуулах ба үнэлгээтэй холбоотой мэдээллийг нууцлан хадгалах үүрэгтэй.
- 4.5 ТУЗ-ийн дарга гишүүдийн өгсөн үнэлгээнд дүн шинжилгээ хийж, ТУЗ-ийн нийт гишүүд, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, үнэлгээтэй холбоотой мэдээллийг нууцлан хадгалах үүрэгтэй.
- 4.6 ТУЗ-ийн гишүүд нь үнэлгээний асуулгыг бөглөх явцад тодорхой бус, ойлгомжгүй асуултын талаар тодруулга хийх, асуулт тавих эрхтэй.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн гэрээний дагуу Компани болон холбогдох этгээдүүдийн өмнө хариуцлага хүлээнэ.